**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ГАЗРЫН 2018 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**
/2018.10.26 - 2018.11.25/

2018 оны 11дүгээр сарын 25 Замын-Үүд сум

| № | Бүтээгдэхүүний нэр | Биелэлт |
|---|---|---|
| 1 | 2 | 3 |
| | **Нэг. Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр** | |
| 1 | Хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах үйл ажиллагааг зохион байгуулна. | Хууль тогтоомж зөрчсөн БНХАУ-ын 6 иргэнд зөрчлийн тухай хуулийн 16.2.3.3-д заасны дагуу 4.770.000 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, ГИЭЗБТх-ийн 37.1.12 дугаар зүйл болон Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан Гадаадын иргэнийг Монгол улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журамын 3.12.1, 3.12.2 дахь заалтад заасны дагуу МУ-д 1 болон 2 жилийн хугацаанд дахин нэвтрэх эрхгүйгээр албадан гаргаж ажилласан болно. |
| 2 | Монгол Улсад байх, буцах хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилгоосоо өөр төрөл ангиллын визтэй зорчиж буй гадаадын иргэнийг хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг нарийн тогтоож материал бүрдүүлэн ажиллах | Боомт, орон нутгийн хэлтсийн даргын 2017.05.26-ны өдрийн 11/2092 тоотийг үндэслэн хил орчмын нутаг, дэвсгэрт зорчих үнэмлэхтэй БНХАУ-ын 2441 иргэн /давхардсан тоогоор/-ний хөдөлгөөнд, бүртгэлээр хяналт тавьж ажилласан. |
| 3 | Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил гаргасан гадаадын иргэдийн зөрчлийг арилгаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажиллана. | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг зөрчсөн 3 орны 29 иргэнийг 10,610.000 мянган төгрөг, 9 аж ахуйн нэгж байгууллагын 49 иргэнд 6.300.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, зөрчлийг арилган, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. |
| 4 | Хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулах | Тайлант хугацаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийгдээгүй, иргэдээс ирсэн өргөдөл гомдол байхгүй. |

| 1 | 2 | 3 |
|---|---|---|
| 5 | Замын-Үүд авто зам, төмөр замын боомтоор зорчиж байгаа гадаадын иргэдэд орох, гарах-орох, дамжин өнгөрөх виз олгох | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн виз олгохыг хүссэн 3 орны 53 иргэнд зохих зориулалт ангиллын визийг олгож, визийн хураамж болох 4,528.000 төгрөг, визийн үнэ болох 430,200 төгрөгийг Төрийн сангийн зохих дансанд нь төвлөрүүлэн ажилласан. Үүнд:<br>• Нэг удаагийн орох – 8 иргэн<br>• Нэг удаагийн гарах, орох – 40 иргэн<br>• Визийн шилжүүлэг – 2 иргэн<br>• Нэг удаагийн дамжин өнгөрөх – 1 иргэн |
| 6 | Виз, түр ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шийдвэрлэн, бүртгэл хөтөлж, мэдээллийн санд баяжилт хийх | Түр ирэгчээр 3 орны 36 гадаадын иргэн бүртгэн, бүртгэлийн хураамж болох 68000 төгрөгийг зохих дансанд төвлөрүүлсэн.<br>Насанд хүрээгүй тул торгуулиас чөлөөлөгдөн бүртгэлд хасалт хийлгэсэн БНХАУ-2, Зөрчил гарган, захиргааны шийтгэл ногдуулсан БНХАУ-ын 40, БНФУ-1, Хонг Конг- 1, ХБНГУ- 2 иргэн байна. Оршин суух зөвшөөрөлд уригчийн хүсэлтээр хасалт хийж, ОСЗ хураалгасан БНХАУ-ын 117 иргэнд хасалт хийж Монгол Улсаас гаргасан болно. |
| **Хоёр. Захиргаа, удирдлага, хүний нөөцийн чиглэлээр** | | |
| 7 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, санал хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас хайрцаг/ дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. | Тайлант хугацаанд тус газрын бичиг хэрэгт 15 албан бичиг ирснийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэлжүүлэн холбогдох албан хаагчид хүлээлгэн өгч, хариутай 7 албан бичгийн хариуг өгч, 16 албан бичиг боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлсэн. Албан хаагчдаас чөлөө хүссэн 1 өргөдөл ирснийг шийдвэрлэсэн. Харин тус газарт ирсэн гомдол байхгүй болно. |
| 8 | Хуулийн хэлэлцүүлэг зохион байгуулах | Гадаадын иргэн, харьяатын газрын даргатай байгуулсан Үр дүнгийн гэрээний үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.1 дэх хэсгийн дагуу Дорноговь аймаг дахь газрын даргын А/22 дугаар тушаалаар баталсан “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн хүрээнд хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах тухай хэлэлцүүлэг”-ийг тус газар өөрийн байранд 2018 оны 11 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулав. |

| 1 | 2 | 3 |
|---|---|---|
| **Гурав.Санхүүгийн чиглэлээр** | | |
| 9 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, өр авлагагүй ажиллах | 2018 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд санхүүжилтийн 33,914,600.00 төгрөг, нийгмийн даатгалын сангаас 351,732.00 төгрөгийн орлогын гүйлгээ, зарлагын 39,237,759.53 төгрөгийн гүйлгээг Замын-Үүд төрийн сангаар хянуулан хийлгэж данс бүртгэлд бүртгэсэн. Үүнд:<br>• Цалин хөлс болон нэмэгдэл урамшил- 23,930,485.90 төгрөг<br>• Нийгмийн даатгалын шимтгэл- 2,949,398.63 төгрөг<br>• Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал- 2,889,645.00 төгрөг<br>• Тээвэр шатахууны зардал- 1,800,000.00 төгрөг<br>• Хангамж, бараа материалын зардал- 2,448,408.00 төгрөг<br>• Эд хогшил, урсгал засварын зардал- 4,108,500.00 төгрөг<br>• Томилолт, зочны зардал- 0.00 төгрөг<br>• Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал- 0.00 төгрөг<br>• Бараа үйлчилгээний бусад зардал- 690,300.00 төгрөг<br>• Ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардал- 0.00 төгрөг<br>• Нийгмийн даатгалын сангийн зарлага-421,022.00<br>2018 оны 11 дүгээр сарын урьдчилгаа цалин болон сарын сүүлийн цалинд 23 албан хаагчид бодож олгосон. |
| 10 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Дорноговь аймгийн Төрийн аудитаас “Шилэн дансны хэрэгжилт шалгалт”-нд 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Сайншанд суманд очиж шалгуулсан.<br>• “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханган:<br>• Тухай бүрт нь оруулах мэдээл-8<br>• Сар бүр оруулах мэдээлэл-3<br>• Улирал бүр оруулах мэдээлэл-1 нийт 12 мэдээллийг хуулийн хугацаанд шилэн дансны сайтад шивж байршуулсан хоцроож байршуулсан мэдээлэл байхгүй.<br>Мөн 10 дугаар сарын Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн сарын болон гуравдугаар улирлын тайланг 2018 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлэн ажилласан. |

| 1 | 2 | 3 |
|---|---|---|
| 11 | Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, бусад тайланг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах | Дорноговь аймгийн Төрийн аудитын газраас Татварын бус орлогод шалгалт хийгдэж 2016-2017 он, 2018 оны 3 дугаар улирлын байдлаар хүү торгуулийн орлогын тайлан мэдээний нэгтгэлийг хийж Төрийн аудитын газарт хүргүүлэв.<br>2018 оны 10 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг 2018 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр гарган Замын-Үүд сумын Төрийн сангийн мэргэжилтнээр хянуулан, Санхүүгийн хэлтэст хүргүүлсэн.<br>2018 оны 10 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг гаргаж 20 албан хаагчдын дэвтэрт бичилт хийн, нийгмийн даатгалын цахим сайтад шивж, нийгмийн даатгалын тасгаар баталгаажуулсан. |
| 12 | Уулзалтын өрөө болон үйлчлэгчийн өрөөнд иж бүрэн засвар хийх | Албан конторын Уулзалтын өрөө 301 тоот өрөө болон үйлчлэгчийн өрөөг замаска, эмульс хийж, уналттай тааз хийж гэрэлтүүлгийг сайжруулсан. Мөн Дотоод тохижилтийг сайжруулах хүрээнд шинээр 55 инч телевизор болон хивсэнцэр дэвссэн.Үйлчлэгийн өрөөний цонхонд хөшиг хийж, гал тогооны тавиур, тек, болон ахуйн хэрэглээний тогоо, плитька, аяга, таваг, халбага, сэрээг шинэчилсэн. |